

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/53/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Санхүүгийн аудитын газрын захирал,

Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663,

Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: П.Чанцалдулам

Утас: 261885

Цахим хаяг: chantsaldulamj@audit.gov.mn

Аудитор: Т.Баасанцэнд

Утас: 261885

Цахим хаяг: Baasantsendt@audit.gov.mn

Грант торнтон аудит ХХК-ийн Гүйцэтгэх
захирал: О.Идшинринжин

Утас: 99993795

Цахим хаяг: info@mn.gt.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА	
1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2. Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5. Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1. Компани түүний үйл ажиллагаа	11
3.2. Компанийн гадаад, дотоод орчин	11
3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1. Ерөнхий зүйл	16
4.2. Материаллаг байдал	17
4.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6.1. Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	18
4.6.2. Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1. Албан шаардлага	19
5.1.1 Компанийн засаглал, хүний нөөцийн удирдлага болон дотоод хяналтын хэрэгжилтэд илэрсэн зөрчил, дутагдал	19
5.1.2 Компанийн засаглал, хүний нөөцийн удирдлага болон дотоод хяналтын хэрэгжилтэд илэрсэн зөрчил, дутагдал	20
5.1.3 Компанийн засаглах удирдлагатай холбоотой	21
5.1.4 Компанийн засаглах удирдлагатай холбоотой	22
5.1.5 Дэмжих баримтын бүрдэл дутуу	23
5.2. Зөвлөмж	23
5.2.1 НББОУС 19 "Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж"	23
5.2.2 НББОУС 16 Үндсэн хөрөнгө "Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой"	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УУБ	Уул уурхайн бүтээгдэхүүн
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХОС	Хөрөнгө оруулалтын сан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/674
танай _____-ны № _____-т

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.МӨНХБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын Хөрөнгийн Бирж ХК -ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд аж ахуйн нэгж болон хуулийн этгээдүүд нь Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаанд оролцохоор журмын дагуу нийт 1,199,250.6 сая төгрөгийн дэнчинг байршуулснаас арилжаанд ялсан 991,174.9 сая төгрөгийн дэнчин битүүмжлэгдсэн, 208,075.7 сая төгрөгийн идэвхтэй дэнчин Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн харилцах дансанд байна.

Аудитын гол асуудал

Барилгын дотоод зохион байгуулалтын зураг, төсвийн дагуу оффисын тохижилтод болон мэдээлэл, үйлчилгээний нээлттэй төвийн дагалдах эд хогшилд 40 нэр төрлийн тавилга, эд хогшил худалдан авахаас 216.1 сая төгрөгийг төсөвлөсөн боловч 1 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын газраас төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд хөрөнгийг үр ашигтай зарцуулах, тэвчиж болох зардлыг хэмнэх, зарим хөрөнгө оруулалтыг хасах, эрэмбэлэн ажиллах чиглэл ирүүлсэнтэй холбоотой гүйцэтгэл хийгдээгүй байна.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын Зөвлөл (IASB) 2024 онд баталсан IFRS 18 "Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга" стандарт нь 2027 оноос хэрэгжиж эхлэх бөгөөд өмнөх IAS 1-ийг орлож, санхүүгийн тайланг илүү ойлгомжтой, нэг загвартай, хөрөнгө оруулагчдад хэрэгцээтэй мэдээлэл өгөх зорилготой тул үүнтэй холбоотойгоор компани дараах зүйлсийг урьдчилан бэлтгэх шаардлага байна. Үүнд:

- Шинэ тайлангийн бүтэц, ангилалд нийцүүлэхийн тулд мэдээллийн систем, дансны төлөвлөгөө, бүртгэлийн зохион байгуулалт, дотоод процесс, журмуудаа хянаж шаардлагатай өөрчлөлтийг хийж, дансны ангилал, мэдээллийн урсгал, автоматжуулалтын тохиргоо болон дотоод хяналтыг шинэ шаардлагад нийцүүлэх;
- Үйл ажиллагааны түвшний шинэ ангилалуудыг ашиглах болсонтой холбоотой одоо ашиглаж буй гүйцэтгэлийн үзүүлэлтүүдэд өөрчлөлт гарах эсэхийг үнэлж, зээлийн гэрээний шалгуур, нөхцөл, менежментийн урамшууллын тооцоололд нөлөөлөх эрсдэлийг урьдчилан тооцох;
- Стандартын нөлөөг бодитоор үнэлж, хэрэгжилтийн бэлтгэлийг үе шаттайгаар ханган, шинэ тайлангийн бүтэц болон удирдлагын ашигладаг гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийн (MPM) талаарх мэдээллийг ил тод, ойлгомжтой байдлаар тайлагнах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Бусад асуудлын хэсэг

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 5 дугаар сарын 02-ны өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын хянаж баталгаажуулсан Компанийн 2024 оны засаглалын кодекс-ийн хэрэгжилтийн тайлангийн дүгнэлт нь 100 хувь, хэвийн буюу эрсдэлгүй гэж заасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Д.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	816,117,554,232.94	1,203,493,790,715.08
1.1.2	Дансны авлага	936,933,524.46	1,455,776,066.72
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	34,072,853.11	350,939,590.54
1.1.4	Бусад авлага	2,148,534,565.92	3,131,683,199.16
1.1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	-	50,781,268,218.27
1.1.7	Бараа материал	47,311,807.77	51,333,607.37
1.1.11	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	30,693,452.28	262,724,745.63
	Эргэлтийн хөрөнгийн дүн	819,315,100,436.48	1,259,527,516,142.77
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	7,328,148,183.23	8,778,595,320.09
1.2.2	Биет бус хөрөнгө	17,044,540,713.61	16,474,042,108.49
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	24,372,688,896.84	25,252,637,428.58
1.3	Нийт хөрөнгө	843,687,789,333.32	1,284,780,153,571.35
2	Өр төлбөр ба эздийн өмч		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	91,733,714.37	411,010,542.17
2.1.1.2	Цалингийн өглөг	5,815,835.99	3,225,616.81
2.1.1.3	Татварын өглөг	235,985,175.46	559,178,988.67
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	109,442,220.57	26,801,554.93
2.1.1.12	УУБ-ны арилжааны дэнчинд байршиж буй мөнгө	767,771,156,772.44	1,192,815,215,717.84
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	768,214,133,718.83	1,193,815,432,420.42
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	635,862,600.00	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	928,380,130.26	960,250,351.36
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,564,242,730.26	960,250,351.36
2.2	Өр төлбөрийн нийт дүн	769,778,376,449.09	1,194,775,682,771.78
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч		
2.3.3	а) төрийн	23,130,593,600.00	23,130,593,600.00
2.3.6	б) хувьцаат	11,915,760,300.00	11,915,760,300.00
2.3.8	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	20,005,435,662.81	19,987,924,558.50
2.3.9	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	446,321,902.02	-
2.3.10	Хуримтлагдсан ашиг	18,411,301,419.41	32,752,909,954.54
2.3.11	Эрсдэлийн сан	-	2,217,282,386.53
2.3.12	Эздийн өмчийн дүн	73,909,412,884.24	90,004,470,799.57
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	843,687,789,333.33	1,284,780,153,571.35

2.2. Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	13,521,664,119.64	10,744,739,531.52
2	Борлуулалтын өртөг	5,166,647,083.45	5,876,432,371.22
3	Нийт ашиг	8,355,017,036.19	4,868,307,160.30
5	Хүүгийн орлого	33,116,453,514.06	34,641,946,857.69
8	Бусад орлого	23,649,812.00	40,238,646.00
9	Борлуулалт маркетингийн зардал	671,207,509.55	748,992,318.26
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,624,904,971.74	3,223,214,408.36
12	Бусад зардал	123,399,481.77	430,171,465.05
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/	(99,547,103.77)	241,583,646.71
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	(196,590.99)	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг	37,975,864,704.43	35,389,698,119.03
19	Орлогын татварын зардал	3,799,182,441.16	3,568,299,639.05
20	Татварын дараах ашиг	34,176,682,263.27	31,821,398,479.98
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг	34,176,682,263.27	31,821,398,479.98
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз /гарз/	-	-
24	Орлогын нийт дүн	34,176,682,263.27	31,821,398,479.98

2.3. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Дахин үнэлгээний нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	35,046,353,900.00	20,021,146,332.29	446,321,902.02	(11,434,011,346.80)	44,079,810,787.51
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	38,117.87	38,117.87
Залруулсан үлдэгдэл	35,046,353,900.00	20,021,146,332.29	446,321,902.02	(11,433,973,228.93)	44,079,848,905.38
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	34,176,682,263.27	34,176,682,263.27
Зарласан ногдол ашиг	-	-	-	4,349,252,518.99	4,349,252,518.99
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(15,710,669.48)	-	17,844,904.05	2,134,234.57
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	35,046,353,900.00	20,005,435,662.81	446,321,902.02	18,411,301,419.40	73,909,412,884.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	1,823,968.49	1,823,968.49
Залруулсан үлдэгдэл	35,046,353,900.00	20,005,435,662.81	446,321,902.02	18,413,125,387.89	73,911,236,852.72
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	31,821,398,479.98	31,821,398,479.98
Зарласан ногдол ашиг	-	-	-	16,471,786,333.00	16,471,786,333.00
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	1,770,960,484.51	(1,135,097,884.51)	635,862,600.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(17,511,104.31)	-	125,270,304.18	107,759,199.87
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	35,046,353,900.00	19,987,924,558.50	2,217,282,386.53	32,752,909,954.54	90,004,470,799.57

2.4. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,326,735,166,461.15	1,286,955,171,102.47
1.1.1	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	15,877,265,204.60	9,947,733,099.30
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	14,355,955.00	5,262,319.00
1.1.7	Хүлээн авсан хүүний орлого	31,119,193,464.18	33,586,245,283.01
1.1.9	Бусад мөнгөн орлого	2,279,724,351,837.37	1,243,415,930,401.16
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,410,500,737,760.85	860,176,167,031.14
1.2.2	Ажиллагчдад төлсөн	2,914,157,156.16	3,839,914,926.58
1.2.3	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	826,171,873.76	1,059,349,363.61
1.2.4	Бараа материал худалдан авахад төлсөн	63,964,460.50	41,904,412.00
1.2.5	Ашиглалтын зардалд төлсөн	85,682,299.14	120,874,004.57
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	991,960.00	3,051,899.00
1.2.8	Татварын байгууллагад төлсөн	5,486,589,832.72	4,824,632,706.91
1.2.9	Даатгалын төлбөрт төлсөн	5,106,920.00	4,628,304.00
1.2.10	Зохицуулалтын хөлс, шимтгэл хураамжинд төлсөн	806,790,916.87	543,422,803.32
1.2.11	Бусад мөнгөн зарлага	2,400,311,282,341.70	849,738,388,611.15
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(83,765,571,299.70)	426,779,004,071.33
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,500,000.00	4,715,050,000.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	4,715,050,000.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,165,764,932.69	58,346,302,072.52
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,343,657,781.80	2,054,403,359.80
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	822,107,150.89	735,665,852.64
2.2.3	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	55,556,232,860.08
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,161,264,932.69)	(53,631,252,072.52)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.4	Бусад мөнгөн орлого	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	16,186,706,237.35
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	16,186,706,237.35
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(16,186,706,237.35)
4	Валютын ханшийн зөрүү	461,575,948.40	30,415,190,720.69
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(86,465,260,283.98)	387,376,236,482.15
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	902,582,814,516.91	816,117,554,232.93
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	816,117,554,232.94	1,203,493,790,715.08

2.5. Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

(Мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйцэтгэл	Хувь	2025 он төлөвлөгөө, гүйцэтгэл	Хувь
						2025 гүйцэтгэл			
НИЙТ ОРЛОГО		М.Төг	46,661,767.5	42,693,289.0	45,426,925.0	1,234,842.5	97%	(2,733,636.0)	106%
A	Үйл ажиллагааны орлого	М.Төг	13,545,314.0	11,287,281.0	10,784,978.1	2,760,335.9	80%	502,302.9	96%
1	Хувьцааны арилжааны шимтгэл	М.Төг	2,009,563.5	2,635,801.0	1,718,625.3	290,938.2	86%	917,175.7	65%
2	Бондын арилжааны шимтгэл	М.Төг	1,079,234.1	789,367.0	299,630.6	779,603.5	28%	489,736.4	38%
3	ХОС-ийн нэгж эрх, ХБҮЦ арилжааны шимтгэл	М.Төг	224,932.6	95,719.0	106,618.7	118,313.9	47%	(10,899.7)	111%
4	Нүүрсний арилжааны шимтгэл	М.Төг	7,506,273.5	5,456,190.0	5,000,342.2	2,505,931.3	67%	455,847.8	92%
5	Төмөр жоншны арилжааны шимтгэл	М.Төг	524,816.8	387,362.0	1,260,949.3	(736,132.5)	240%	(873,587.3)	326%
6	Зэс арилжааны шимтгэл	М.Төг	36,818.8	165,337.0	321,622.2	(284,803.4)	874%	(156,285.2)	195%
7	Гишүүнчлэлийн жилийн хураамж	М.Төг	108,590.9	86,327.0	86,133.4	22,457.5	79%	193.6	100%
8	Терминал ашигласны хураамж	М.Төг	66,836.4	65,236.0	78,522.7	(11,686.3)	117%	(13,286.7)	120%
9	Үнэт цаас бүртгэх үйлчилгээний орлого	М.Төг	539,022.1	371,818.0	123,036.3	415,985.8	23%	248,781.7	33%
10	УУБ бүртгэх үйлчилгээний хөлс	М.Төг	558,454.5	361,000.0	882,636.4	(324,181.9)	158%	(521,636.4)	244%
11	Бүртгэлтэй компанийн жилийн хураамж	М.Төг	493,864.1	537,104.0	543,926.2	(50,062.1)	110%	(6,822.2)	101%
12	Сургалтын орлого	М.Төг	11,809.1	43,273.0	15,645.5	(3,836.4)	132%	27,627.5	36%
13	Мэдээллийн үйлчилгээний орлого	М.Төг	208,990.5	204,111.0	218,781.6	(9,791.1)	105%	(14,670.6)	107%
14	Бусад орлого	М.Төг	176,107.1	88,636.0	128,507.7	47,599.4	73%	(39,871.7)	145%
Б	Үйл ажиллагааны бус орлого		33,116,453.5	31,406,008.0	34,641,946.9	(1,525,493.4)	105%	(3,235,938.9)	110%
1	Хүүгийн орлого	М.Төг	33,116,453.5	31,406,008.0	34,641,946.9	(1,525,493.4)	105%	(3,235,938.9)	110%
В	Нийт зардал		8,586,355.6	11,211,581.8	10,278,810.8	(1,692,455.2)	120%	932,771.0	92%
1	Ажилтнуудын цалин хөлс	М.Төг	3,274,128.2	4,456,039.0	4,173,607.1	(899,478.9)	127%	282,431.9	94%

Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйцэтгэл	Хувь	2025 он төлөвлөгөө, гүйцэтгэл	Хувь
						2025 гүйцэтгэл			
2	НДШ-ийн зардал	М.Төг	406,734.0	554,674.0	520,216.6	(113,482.6)	128%	34,457.4	94%
3	Удирдлагын зардал	М.Төг	394,458.4	544,406.0	507,622.7	(113,164.3)	129%	36,783.3	93%
4	Материал, бичиг хэрэг	М.Төг	32,022.7	49,216.0	38,078.3	(6,055.6)	119%	11,137.7	77%
5	Харилцаа холбооны зардал	М.Төг	8,628.4	13,716.0	9,030.7	(402.3)	105%	4,685.3	66%
6	Интернет ашиглалт	М.Төг	12,659.3	20,093.0	13,596.0	(936.7)	107%	6,497.0	68%
7	Программ хангамж ашиглалтын зардал	М.Төг	6,653.0	15,771.0	15,565.7	(8,912.7)	234%	205.3	99%
8	Шатахуун, тээврийн хэрэгслийн зардал	М.Төг	-	9,370.0	2,310.3	(2,310.3)	10000%	7,059.7	25%
9	Урсгал засвар	М.Төг	31,866.6	35,763.0	33,188.4	(1,321.8)	104%	2,574.6	93%
10	Цахилгаан, дулаан, ус, хог	М.Төг	48,819.6	77,466.0	65,551.7	(16,732.1)	134%	11,914.3	85%
11	Албан томилолт	М.Төг	131,883.6	162,096.0	118,215.1	13,668.5	90%	43,880.9	73%
12	Сургалт семинар	М.Төг	118,478.4	201,505.0	19,414.3	99,064.1	16%	182,090.7	10%
13	Ажилтнуудын нийгэм, соёлын зардал	М.Төг	95,132.8	355,800.0	202,732.6	(107,599.8)	213%	153,067.4	57%
14	ЗЗ идэвхжүүлэлт, бизнес харилцааны зардал	М.Төг	117,083.7	225,807.0	130,815.0	(13,731.3)	112%	94,992.0	58%
15	ХЭХ зохион байгуулалтын зардал	М.Төг	9,542.9	54,842.0	18,116.4	(8,573.5)	190%	36,725.6	33%
16	Мэдээлэл технологийн зардал	М.Төг	100,313.1	177,277.0	71,182.6	29,130.5	71%	106,094.4	40%
17	Мэдээллийн үйлчилгээний зардал	М.Төг	-	105,000.0	102,765.1	(102,765.1)	10000%	2,234.9	98%
18	Бусад зардал	М.Төг	116,734.7	123,031.0	112,173.8	4,560.9	96%	10,857.2	91%
19	ҮХХ-ийн татвар	М.Төг	24,301.8	48,604.0	48,603.6	(24,301.8)	200%	0.4	100%
20	Элэгдлийн зардал	М.Төг	679,631.7	978,182.0	915,788.0	(236,156.3)	135%	62,394.0	94%
21	Зохицуулах үйлчилгээний хөлс /СЗХ/	М.Төг	1,138,052.7	860,328.0	870,682.6	267,370.1	77%	(10,354.6)	101%
22	Систем ашиглалтын зардал:	М.Төг	1,688,722.7	1,846,708.8	1,847,319.1	(158,596.4)	109%	(610.3)	100%
	Үүнд: Системийн элэгдлийн зардал	М.Төг	684,335.7	684,335.7	684,335.7	-	100%	-	100%
	Системийн үйлчилгээний зардал	М.Төг	1,004,387.0	1,162,373.1	1,162,983.4	(158,596.4)	116%	(610.3)	100%

Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйцэтгэл	Хувь	2025 он төлөвлөгөө, гүйцэтгэл	Хувь
						2025 гүйцэтгэл			
23	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал	М.Төг	132,780.0	235,800.0	149,039.9	(16,259.9)	112%	86,760.1	63%
24	Болзошгүй зардал	М.Төг	17,727.3	60,087.0	19,727.0	(1,999.7)	111%	40,360.0	33%
25	Найдваргүй авлагын зардал	М.Төг		-	273,468.2	(273,468.2)	100%	(273,468.2)	100%
Г	Үйл ажиллагааны ашиг алдагдал (А+Б)-В	М.Төг	38,075,411.9	31,481,707.2	35,148,114.5	2,927,297.4	92%	(3,666,407.3)	112%
6	Гадаад валютын ханшийн бодит бус цэвэр орлого	М.Төг	(99,547.1)		241,583.6	(341,130.7)		(241,583.6)	
Д	Татварын өмнөх цэвэр ашиг (Г+Д)	М.Төг	37,975,864.8	31,481,707.2	35,389,698.1	2,586,166.7	93%	(3,907,990.9)	112%
	Орлогын албан татвар	М.Төг	3,799,182.4	-	3,568,299.6	230,882.8		(3,568,299.6)	
Е	Татварын дараах цэвэр ашиг	М.Төг	34,176,682.4	-	31,821,398.5	2,355,283.9		(31,821,398.5)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1. Компани түүний үйл ажиллагаа

Монголын Хөрөнгийн Бирж ХК нь Монгол улсад үнэт цаасны арилжаа эрхлэх болон болон уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тусгай зөвшөөрөл бүхий төрийн 66 хувийн өмчит, олон нийтийн 34 хувийн өмчлөлтэй хуулийн этгээд юм. Компани нь 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр байгуулагдсан цагаасаа эхлэн үнэт цаасны арилжааны биржийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Монголын хөрөнгийн бирж ХК нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу компанийн хувьцаа, өрийн хэрэгсэл, Засгийн газрын үнэт цаас, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бэлтгэх, анхдагч болон хоёрдогч зах зээлд арилжих, арилжаанд хяналт тавих, журам болон гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, хариуцлага ногдуулах, Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан үнэт цаасны компанийг гишүүнээр элсүүлэх, арилжаанд оролцох нөхцөлөөр хангах, үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлага ногдуулах зэрэг үндсэн үйл ажиллагаанаас гадна уул уурхайн бүтээгдэхүүнийг бүртгэх, арилжих, зах зээлд оролцогчдыг бүртгэн итгэмжлэх, арилжааны зуучлагчийн тусгай зөвшөөрөлтэй этгээдийг уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны гишүүнээр элсүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих, журам болон гэрээгээр хүлээх үүргийн хэрэгжилтийг хангуулах, хариуцлага ногдуулах арга хэмжээг 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлсэн байна.

3.2. Компанийн гадаад, дотоод орчин

Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийг Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 22 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч Засгийн газар томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусвар болгох;” Компанийн удирдлагыг Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор томилж байгаа нь компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 1.8 дахь заалт “Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох” гэсэн заалтуудтай нийцэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 1.3 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт;

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт,
- ТУЗ-ийн 2025 оны 01 дүгээр сарын 13-ний өдрийн А/12 тоот тогтоолоор шинэчлэн баталсан “өмч хамгаалах зөвлөлийн ажиллах журам”;
- ТУЗ-ийн 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/370 тоот тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан бизнесийн тасралтгүй байдлын журам;
- ТУЗ-ийн 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/371 тоот тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан “Зөрчлийн удирдлагын журам”;
- ТУЗ-ийн 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/372 тоот тогтоолоор тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан “мэдээллийн аюулгүй байдлын менежментийн дотоод аудитын журам”;
- ТУЗ-ийн 2025 оны 8 дугаар сарын 13-ний өдрийн А/43 тоот тогтоолоор шинэчлэн баталсан “үнэт цаасны бүртгэлийн журам”.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын алба нь хорооны дарга, хорооны 2 гишүүд болон чиглэл хариуцсан 2 аудиторын бүрэлдэхүүнтэйгээр ажилладаг. ТУЗ-ийн 2024 оны 05 сарын 22-ны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Дотоод аудитын үйл ажиллагааны журам-ыг мөрдөж ажилладаг.

Тайлант жилд ТУЗ-ийн тогтоолоор батлагдсан дотоод аудитын 2025 оны төлөвлөгөөнд бизнес төлөвлөгөөний хэрэгжилт, ТУЗ-ийн үүрэг даалгаврын хэрэгжилт, хүний нөөц, дэнчингийн мөнгөн хөрөнгийг удирдах үйл ажиллагаа, бизнес хөгжлийн газарт хийгдэх аудит, компанийн хэмжээнд худалдан авалтын аудит гэсэн нийт 6 зорилтот аудитын ажил тусгагдсан байна. Төлөвлөгөөний дагуу бүх ажлыг хийж гүйцэтгэн 7 зөвлөмж хүргүүлж, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын албаны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурийн дагуу бүртгэж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалд нийцүүлэн бэлтгэсэн байна.

Тус компани Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 278 дугаар тогтоолоор баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрддөг бөгөөд тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, СТОУС, нягтлан бодох бүртгэлийн стандартуудын шаардлагад нийцсэн боловч компанийн үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна. Тайлант жилд компани нь “зардлын чиг үүрэг” буюу “борлуулалтын өртөг”-

ийн аргаар орлогын дэлгэрэнгүй тайлан бэлтгэж эхэлсэн ба үүнтэй холбоотойгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 9 дүгээр сарын өдрийн 29-ний өдрийн А414 тоот тогтоолоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулсан байна.

3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн санхүүгийн тайланд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын хэрэгжилтийг үнэлэх аудитын горим хэрэгжүүлсний үндсэн дээр тус компани санхүүгийн тайлангаа СТОУС, нягтлан бодох бүртгэлийн стандартуудад нийцүүлэн, мөн Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэж, толилуулсан гэж үзсэн.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 441,092.3 сая төгрөгөөр буюу 52 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	816,117,554.3	1,203,493,790.7	387,376,236.5
Авлага	3,119,540.9	4,938,398.9	1,818,858.0
Бараа материал	47,311.8	51,333.6	4,021.8
Бусад санхүүгийн хөрөнгө	-	50,781,268.2	50,781,268.2
Урьдчилж төлсөн зардал	30,693.4	262,724.7	232,031.3
Үндсэн хөрөнгө	7,328,148.2	8,778,595.3	1,450,447.1
Биет бус хөрөнгө	17,044,540.7	16,474,042.1	(570,498.6)
Нийт хөрөнгө	843,687,789.3	1,284,780,153.5	441,092,364.2
Өр төлбөр	769,778,376.4	1,194,775,682.7	424,997,306.3
Эздийн өмч	73,909,412.9	90,004,470.8	16,095,057.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	843,687,789.3	1,284,780,153.5	441,092,364.2

Дээрх хүснэгтээс харахад материаллаг өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, авлага, бусад санхүүгийн хөрөнгө, урьдчилж төлсөн зардал, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, богино болон урт хугацаат өр төлбөр, хуримтлагдсан ашиг, алдагдлын дансдууд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө 387,376.2 сая төгрөгөөр өссөн шалтгаан нь уул уурхайн бүтээгдэхүүний арилжаанд оролцогч талуудын байршуулсан дэнчин өмнөх оноос нэмэгдсэнтэй холбоотой мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэн байна.

Авлага 1,818.8 сая төгрөгөөр өссөн нь хадгаламжийн дансны хүүний авлага өмнөх оноос 881.0 сая төгрөг, нүүрсний арилжаа, төмрийн арилжааны шимтгэлийн авлага 857.8 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй голлон холбоотой байна.

Бусад санхүүгийн хөрөнгөд арилжааны банкнуудад байршуулсан 12 сарын хугацаатай хадгаламжийн үлдэгдлийг тайлагнадаг ба завсар үеийн санхүүгийн тайлангийн аудитаар НББОУС 7 мөнгөн гүйлгээний тайлан стандартын шалгуур үзүүлэлтийн дагуу мөнгө түүнтэй адилтгах хөрөнгөөс 50,781.2 сая төгрөгийн урт хугацаат хадгаламжийг бусад санхүүгийн хөрөнгө данс руу залруулсан тул дансны үлдэгдэл нэмэгдсэн байна.

Урьдчилж төлсөн зардал 232.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Монголын Хөрөнгийн Бирж 2012 оноос эхлэн ашиглаж байгаа Лондонгийн хөрөнгийн биржийн Millennium IT (Millennium

Exchange) технологид суурилсан өндөр хурдны электрон арилжааны платформ бөгөөд тус системийг ашиглах лицензийн төлбөрийг урьдчилж төлсөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө 1,450.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь барилгын дотоод зохион байгуулалтын зураг төслийн дагуу оффисын тохижилтод болон мэдээлэл, үйлчилгээний нээлттэй төвийн дагалдах эд хогшил, мөн дотоодын хөгжүүлсэн системүүдийн тасралтгүй, хүртээмжтэй, бэлэн байдлыг хангах зорилгоор серверүүдийн нэгдсэн дэд бүтэц бий болгоход шаардагдах сервер болон хадгалах төхөөрөмжүүдийг 698.3 сая төгрөгөөр, оффисын ажилтнуудын ажлын байрны хэрэгцээнд зориулсан сканнер, компьютер, принтер, оффисын тоног төхөөрөмжүүдийг 366.7 сая төгрөгөөр худалдан авсан мөн оффисын дотоод засвар үйлчилгээ хийж барилга байгууламжыг 2,352.9 сая төгрөгөөр капиталжуулснаас голлон шалтгаалсан байна.

Биет бус хөрөнгийн үлдэгдэл 570.4 сая төгрөгөөр буурсан нь Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, ТУЗ-ийн тогтоолын дагуу 146.0 сая төгрөгийн анхны өртөгтэй, хуримтлагдсан элэгдэлтэй, үлдэх өртөггүй биет бус хөрөнгийн акталсан мөн тайлант хугацаанд биет бус хөрөнгөд тооцсон 1,124.4 сая төгрөгийн хорогдуулгаас шалтгаалсан байна.

Өр төлбөрийн үлдэгдэл 424,997.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ААНОАТ-ын өглөг 176.9 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг 118.9 сая төгрөг, мөн тайлант хугацаанд уул уурхайн бүтээгдэхүүний арилжаанд оролцох журмын дагуу нийт 767,789.2 сая төгрөгийн дэнчинг байршуулснаас арилжаанд ялсан 726,436.1 сая төгрөгийн дэнчинг битүүмжилтэй холбоотой байна.

Эздийн өмчийн үлдэгдэл 16,095.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант хугацаанд 31,821.4 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласнаас хуримтлагдсан ашиг 14,381.6 сая төгрөг, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа төлбөр тооцоо хийх ерөнхий журмын дагуу биржийн эрсдлийн санг 2,217.2 сая төгрөгөөр тооцоолж бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

3.5. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу хөрөнгө оруулалт болон зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөл 2024 оны 12 дугаар сарын 19-ний 61 дүгээр тогтоолоор 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 1,202.1 сая төгрөгөөр баталж, Төлөөлөн удирдах зөвлөл 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 54 дүгээр тогтоолоор тодотгол хийж 1,473.1 сая төгрөг болгож 271.0 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Дээрх орлого, зардал, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2025 оны 10 дугаар сарын 06-ны 54 дүгээр тогтоолоор тодотгол хийж орлого зардалын төлөвлөгөөнд нийт зардлыг 126.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, тайлант оны нийт орлогыг 42,693.3 сая төгрөг, нийт зардлыг 11,211.6 сая төгрөгөөр баталж, 3,148.2 сая төгрөгийн татварын зардал тооцож, 28,333.5 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөсөн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Эдийн засгийн зорилтод түвшнийг батлуулахдаа компанийн үйл ажиллагааны онцлогт тохируулан орлого, зардлын үзүүлэлт тус бүрээр батлуулдаг байна.

Хүснэгт 2. Зорилтот түвшний төлөвлөгөө гүйцэтгэлийн хураангуй үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт	Хувь
Нийт орлого	42,693,289.0	45,668,508.6	(2,975,219.6)	106%
Нийт зардал	11,211,581.8	10,278,810.5	932,771.0	92%
Татварын өмнөх ашиг	31,481,707.2	35,389,698.1	(3,907,990.9)	112%
Орлогын албан татварын зардал	3,148,236.2	3,568,299.6	(420,063.4)	113%
Цэвэр ашиг	28,333,471.0	31,821,398.5	(3,487,927.5)	112%

Гүйцэтгэлээр 45,668.5 сая төгрөгийн орлого бүрдүүлсэнээс 45,426.9 сая төгрөг нь үндсэн үйл ажиллагааны орлого, 241.5 сая төгрөг нь гадаад валютын ханшийн зөрүүний бодит олз бүртгэсэн байна. Үндсэн үйл ажиллагааны орлого 2,975.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь дэнчингийн харилцах дансны үлдэгдэлд тооцсон 34,641.9 сая төгрөгийн хүүгийн орлогоос голлон нөлөөлжээ. нийт зардалд 10,278.8 сая төгрөг, орлогын албан татварын зардалд 3,568.3 сая төгрөгийг тайлагнаж, 31,821.4 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 10,278.8 сая төгрөг болж, 92 хувьтай байгаа нь ТУЗ-ийн тогтоолоор 72 ажилтны орон тоо баталснаас 2025 онд 70 ажилтантай ажиллаж, цалин хөлсийг ажлын гүйцэтгэлтэй уялдуулан олгож, цалин хөлсний зардлыг 899.4 сая төгрөг, шатахуун, тээвэр, бизнес харилцааны зардал, зах зээл идэвхижүүлэлтийн зардлыг 16.0 сая төгрөг, арилжааны системийн ашиглалтын зардлыг 236.1 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна. Мөн компани нь ТУЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор компанийн 2024 оны жилийн эцсийн аудитын өмнөх санхүүгийн тайлангийн татварын дараах цэвэр ашигаас 16,471.7 сая төгрөгийн ногдол ашиг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Компани нь 2025 онд 1,473.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг төлөвлөгөөнд тусгаснаас 1,027.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, 70 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт	Хувь
Үндсэн хөрөнгө:				
Барилга, байгууламж	190,214.0	160,535.8	(29,678.2)	84%
Тавилга эд хогшил	216,102.0	1,980.0	(214,122.0)	1%
Биет бус хөрөнгө	640,132.4	576,710.2	(63,422.2)	90%
Тоног төхөөрөмж	426,672.0	288,502.8	(138,169.2)	68%
Нийт дүн	1,473,120.4	1,027,728.8	(445,391.6)	70%

Хөрөнгө оруулалтаар нийт 99 нэр төрлийн ажил үйлчилгээ явуулахаар 1,473.1 сая төгрөг төлөвлөснөөс 1,027.7 сая төгрөгийн 23 ажил үйлчилгээний худалдан авалт амжилттай хийгдсэн мөн барилгын гадна фасадын засварын ажил болон хаяг солих ажлын

магадлагдсан зураг, төсвийн дагуу барилга байгууламжийн засвар үйлчилгээг хийлгэх ажилд 190.2 сая төгрөгийн төсөвлөж 84 хувийн гүйцэтгэлтэй байна.

Барилгын дотоод зохион байгуулалтын зураг, төсвийн дагуу оффисын тохижилтод болон мэдээлэл, үйлчилгээний нээлттэй төвийн дагалдах эд хогшилд 40 нэр төрлийн тавилга, эд хогшил худалдан авахаас 216.1 сая төгрөгийг төсөвлөсөн боловч 1.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын газраас төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд хөрөнгийг үр ашигтай зарцуулах, тэвчиж болох зардлыг хэмнэх, зарим хөрөнгө оруулалтыг хасах, эрэмбэлэн ажиллах чиглэл ирүүлсэнтэй холбоотой гүйцэтгэл хийгдээгүй байна.

Арилжааны цогц системийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор үндсэн дата төв, нөөц дата төвийн болон программ хангамжийн үйлчилгээ, сайжруулалтад шаардагдах үйлдлийн системийн лиценз 11 ширхэг, oracle 19c database enterprise багц лицензийн үйлчилгээний сургалт 6 удаа, эмзэг байдлыг илрүүлэн, хариу арга хэмжээ авч аюулгүй байдлыг нэмэгдүүлэх pen test software лиценз, оффис программын лиценз худалдан авахад нийт 640.1 сая төгрөгийг төсөвлөж 90 хувийн гүйцэтгэлтэй байна.

Дотоодын хөгжүүлсэн системийн тасралтгүй, хүртээмжтэй, бэлэн байдлыг хангах зорилгоор серверүүдийн нэгдсэн дэд бүтэц бий болгоход шаардагдах сервер болон хадгалах төхөөрөмж, оффисын ажилтнуудын ажлын байрны хэрэгцээнд зориулан сканер, компьютер, принтер, мэдээлэл үйлчилгээний нээлттэй төвийн дагалдах тоног төхөөрөмж зэрэг 45 нэр төрлийн нийт 133 ширхэг тоног төхөөрөмж худалдан авахаар 426.6 сая төгрөг төсөвлөж 68 хувийн гүйцэтгэлтэй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах талаар санхүүгийн тайлангийн олон улсын стандарт болон хууль, дүрэм журамд нийцүүлэн компанийн дотоод хяналт, анхан шатны нотлох баримтын бүрдэлт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Грант Торнтон Аудит ХХК-ийн Аудитор Б.Эрдэнэболд, Туслах аудитор Х.Дүүрэнжаргал, нар гүйцэтгэж, аудитын менежер Л.Болорцэцэг, чанарын хяналтын партнер Н.Эрдэнэцог, гэрээт ажлын партнер Б.Идшинринжин нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Т.Баасанцэнд, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Монголын Хөрөнгийн Бирж ХК нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 01/82 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр “Нийт орлого”-г сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 46,661.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 466.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор компани зайлшгүй шаардлагатайгаас бусад оффисын тавилга эд хогшил худалдан авах зардлыг бууруулах арга хэмжээ авч ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, тус хуулиар хязгаарласан зардлын хүрээнд компани зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж ажилласан эсэхэд горим сорил хэрэгжүүлж холбогдох анхан шатны баримт бичиг, нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл болон шийдвэрүүдийг шалган үнэлэхэд зөрчил илрээгүй бөгөөд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шаардлагыг зохих түвшинд мөрдөн ажилласан байна.

4.4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.5. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг шалгахад мэдээллэх үүрэгтэй Төсөв, гүйцэтгэл-Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн тайлан, Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөв төлөвлөгөөний гүйцэтгэл, цалингийн зардлаас бусад, тендер, худалдан авалттай холбоотой таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын нийт 2,158 ширхэг мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроолгүй ил тод, бүрэн байршуулсан байна.

4.6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2024 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, тодруулгууд, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл, ерөнхий дэвтэр, ерөнхий журнал, анхан шатны баримт, үйл ажиллагааны тайлан болон бусад шаардлагатай баримтуудыг хамруулан дансдын хувьд горим сорил хэрэгжүүлэн аудитын урьдчилсан үйл ажиллагаа болон төлөвлөх үе шатны ажилбаруудыг гүйцэтгэсэн.

4.6.1. Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн 4 албан шаардлага, 1 зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад шийдвэрийн биелэлт 100 хувьтай байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	67,130.0	3	67,130.0	100.0
Зөвлөмж	1	686,531.7	1	686,531.7	100.0
Нийт дүн	5	753,661.7	4	753,661.7	100.0

“Анард” ХХК-иас гаргуулахаар шийдвэрлэсэн он дамжсан авлагыг барагдуулах ажиллагаа хийгдээгүй зөрчлийг арилгаж, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагын биелэлтийг хэрэгжүүлэхдээ Анард ХХК-иас авах авлагыг санхүүгийн тайланд бүртгэж найдваргүй авлагын хасагдуулга тооцсон байна. Учир нь Анард ХХК нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй, өмчлөлд эд хөрөнгө бүртгэлгүй улмаар төлбөрийг барагдуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн байна. Аудитаар нөхцөл байдлыг үнэлэн өмнөх оны албан шаардлагыг биелэлтийг 100 хувь хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн. Тайлант хугацаанд буюу 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар Анард ХХК-тай Улаанбаатар хотын Бэлхийн зусланд ажилчдад зориулсан 16 айлын байр бариулах барилга угсралтын гэрээ байгуулж, 2006-2007 онд гэрээний дагуу 171.5 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг шилжүүлсэн боловч гэрээний үүрэг биелэгдээгүй асуудалд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.6.2. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар компанийн мөрдөж ажилладаг зохицуулах хорооноос гаргасан, дотооддоо боловсруулсан компанийн үйл ажиллагаанд мөрдөж буй зарим дотоод журам, бодлогын баримт бичгүүдийг холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан шинэчлэн баталсан эсэх, хяналтын тогтолцоо бүрэн хэрэгжиж байгаа эсэх, дотоод хяналт, шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлж, дотоод хяналтаар илэрсэн алдаа зөвлөмжид хариу арга хэмжээ авч ажиллаж байгаа эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 360.7 сая төгрөгийн 7 алдаа, зөрчил илэрснээс 240.9 сая төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 119.7 сая төгрөгийн 2 алдаанд дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

5.1. Албан шаардлага

5.1.1 Компанийн засаглал, хүний нөөцийн удирдлага болон дотоод хяналтын хэрэгжилтэд илэрсэн зөрчил, дутагдал

Илрүүлэлт: Компанийн өмнөх Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь өөрийн эрх мэдлийг урвуулан ашиглаж хүний нөөцийн удирдлага болон дотоод хяналтыг сулруулж компанийн санхүүгийн сахилга бат, ил тод байдал, мэдээллийн аюулгүй байдал алдагдах, байгууллагын нөөцийг үр ашиггүй зарцуулах дараах эрсдэлийг бий болгосон байна.

Тухайлбал:

- Өмнөх гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь компанитай байгуулсан хөдөлмөрийн гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд Нийслэлийн “Орон сууцны корпорац” ХК, Нийслэлийн өмчит “Улаанбаатар ХОМК” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр давхар ажилласан нь хөдөлмөрийн гэрээний үүрэг, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчим болон компанийн засаглалын шаардлагатай нийцээгүй
- Ажлын байрны чиг үүргийн шинжилгээ, хэрэгцээ шаардлагыг тодорхойлоогүй, сонгон шалгаруулалт зохион байгуулах ажлын хэсэг байгуулаагүй, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас ирүүлсэн орон тоог нэмэгдүүлэхгүй байх чиглэлийг дагаж мөрдөлгүй нийт 5 ажилтантай туршилтаар ажиллах гэрээ байгуулан ажиллуулсан байна. Гэвч туршилтын хугацаанд гүйцэтгэлийн үнэлгээ хийгдээгүй, зарим ажилтнууд зайнаас ажилласан, цагийн бүртгэл хөтлөгдөөгүй, гүйцэтгэсэн ажлын тайлан, үр дүн тодорхойгүй, ажлын гүйцэтгэлийн баримт хангалтгүй байхад нийт 41.0 сая төгрөгийн төсөвлөгдөөгүй цалингийн зардал гаргасан
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Захирлын зөвлөлийн зөвшөөрөлгүй Эрчист Монгол ХХК-ийн ажилчдыг 2025 оны 05 сарын 09-нөөс 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийг дуустал Б1 давхарт, 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрөөс 2025 оны 08 дугаар сарыг дуустал 2 давхрын хурлын өрөөнд суулган ажиллуулах чиглэл өгч тус компанийн ажилчдыг Монголын хөрөнгийн бирж ХК-ийн үндсэн үйл ажиллагаанд хамааралтай бус, зорилго нь тодорхойгүйгээр урт хугацаанд суулгаж ажиллуулж, өрөө тасалгаа, тавилга, тоног төхөөрөмж, интернэт сүлжээг ашиглуулсан бөгөөд мэдээллийн нууцлалын гэрээ байгуулаагүй байна

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3. “үр ашигтай байх; 4.1.9. хариуцлагатай байх”, 15 дугаар зүйл 15.2.6. “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох”, Хөдөлмөрийн тухай хуулийн 17 дугаар зүйл 17.6. Ажил мэргэжлийн стандартаар хөдөлмөрийн нөхцөл, ажилтны ажлын дадлага, туршлага, мэдлэг, ур чадвар, чадамж, хандлага, мэргэшлийн түвшин, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тогтооно, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47 дугаар зүйл 47.7. “Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын эрх бүхий албан тушаалтан үнэт цаасны арилжаанд оролцогч зохицуулалттай хуулийн этгээдэд алив албан тушаал эрхлэхийг хориглоно.” Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйл 18.1. “Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно.” 27 дугаар зүйл 27.2. “Албан тушаалтан өөрийн үйл ажиллагааны шударга, төвийг сахисан байдалдаа ёс зүйн шалтгаанаар эргэлзээ төрвөл албан үүргээ гүйцэтгэхээс эсхүл давхар ажил, албан тушаал эрхлэхээс татгалзах үүрэгтэй.” Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 8 дугаар зүйл 8.6.14. “хуульд зааснаас бусад тохиолдолд өөр байгууллагад ажил, албан тушаал хавсран эрхлэхгүй байх”, Төрийн

өмчийн хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журмын 1 дүгээр зүйл 1.5. “Хуулийн этгээдийн ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалт явуулахдаа хууль дээдлэх, ил тод, хараат бус байх, ашиг сонирхлоос ангид байх, шударга, эрх тэгш хандах болон нээлттэй өрсөлдөөний зарчмыг удирдлага болгоно”, 2 дугаар зүйл 2.1. “Хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд сонгон шалгаруулалт зарлахаас өмнө дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ”, 2.1.1. “ажлын байранд чиг үүргийн шинжилгээ хийж, ажлын байр тус бүрийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох”, 2.1.2. “ажлын байрыг дараах хүрээнд ангилан тогтоох”, 2.1.3. “ажлын байрны тодорхойлолт (ажил үүргийн тодорхойлолт)-ыг батлах”, 3 дугаар зүйл 3.1. “Ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалт (цаашид "сонгон шалгаруулалт" гэх) зохион байгуулах шийдвэрийг хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал гаргаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн:

1. Дотоод хяналтыг сулруулж компанийн санхүүгийн сахилга бат, ил тод байдал, мэдээллийн аюулгүй байдал алдагдах, байгууллагын нөөцийг үр ашиггүй зарцуулах, эрсдэлийг бий болгосон зөрчлийг таслан зогсоож, ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудит нь Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн ажлын тайланг хянан баталгаажуулж ТУЗ-д танилцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

5.1.2 Компанийн засаглал, хүний нөөцийн удирдлага болон дотоод хяналтын хэрэгжилтэд илэрсэн зөрчил, дутагдал

Илрүүлэлт: Компанийн дотоод хяналтын үйл ажиллагааг үнэлэхэд дотоод хяналтын төлөвлөлт, тайлагнал, удирдлагын хяналт болон дотоод зохицуулалтын шинэчлэл хангалтгүй байна. Тухайлбал:

2025 оны дотоод хяналтын төлөвлөгөөнд тусгасан хяналт шалгалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, дотоод хяналтын тайланг Биржийн гүйцэтгэх удирдлага болон захирлуудын зөвлөлд тогтмол хүргүүлээгүй, мөн хийсэн хяналт шалгалтын дүгнэлт, зөвлөмжид удирдлагын түвшинд үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангах арга, дотоод хяналтаар илэрсэн алдаа, дутагдлыг засаж залруулах зөвлөмж, заавар, арга хэмжээ авдаггүй, Түүнчлэн компанийн үйл ажиллагаанд мөрдөж буй зарим дотоод журам, бодлогын баримт бичгүүдийг холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан шинэчлэн батлаагүй байгаа нь байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн нийцэл алдагдах, дотоод хяналтын тогтолцоо сулрах эрсдэлийг бий болгож байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйл 19.1. Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно, Компанийн тухай хууль 84 дүгээр зүйл 84.4. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй 84.4.1.хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх, 84.4.2.үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх, 84.4.3.компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 145 дугаар тогтоолоор батлагдсан засаглалын кодекс Хавсралт-9 дотоод хяналтын зааврын үлгэрчилсэн загварын 1.1. Энэхүү баримт бичгийг гүйцэтгэх удирдлага нь өөрийн дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ баримтлах зарчим, дотоод хяналтын үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлоход баримтална, 1.4. Дотоод хяналт нь эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, арга зүйн зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэхэд чиглэнэ, 2.4.Дотоод хяналтын нэгж, эсхүл ажилтан нь дараах нийтлэг эрх, үүрэгтэй байна, 2.4.5. шаардлагатай бол илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар гүйцэтгэх удирдлагад санал тавьж, шийдвэрлүүлэх, 2.4.6.хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан

сэргийлэх талаар ажилтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн:

1. Дотоод хяналтын төлөвлөгөөг Гүйцэтгэх захирлаар баталгаажуулан төвлөгөөний дагуу дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, Гүйцэтгэх захирлын батлагдсан "Дотоод хяналт шалгалтын журам"-ын дагуу Биржийн Гүйцэтгэх удирдлага болон захирлуудын зөвлөлд дотоод хяналтын тайланг улирал бүр хүргүүлж байх,
2. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил болон зөвлөмжийн хэрэгжилт биелэлтийг үнэлж хариу арга хэмжээ авч байх, ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудит нь дотоод хяналтын үйл ажиллагааны үр ашигтай байдлыг үнэлэж дүгнэж байх албан шаардлага хүргүүлэв.

5.1.3 Компанийн засаглах удирдлагатай холбоотой

Илрүүлэлт: Компанийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг ТУЗ нь Монгол Улсын Сангийн сайдаас ирүүлсэн албан бичиг болон Компанийн тухай хууль, компанийн дүрмийг үндэслэн тогтоол гарган томилж, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллуулж байна. Үүнээс үүдэн хууль эрх зүй, компанийн засаглалын зохицуулалттай холбоотой дараах гол зөрчил, эрсдэлүүд үүсэхээр байна Тухайлбал:

1. Компанид тогтвортой хугацаанд ажиллах Гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулж томилоогүйн улмаас тайлант хугацаанд дөрвөн удаа Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч солигдсон нь компанийн засаглалын тогтвортой байдал, стратегийн төлөвлөлтөд сөргөөр нөлөөлөх, Удирдлагын байнгын өөрчлөлт нь дунд болон урт хугацааны бодлого, төлөвлөгөөний хэрэгжилт тасалдах, гүйцэтгэлийн шалгуур тогтоох болон хариуцлага тооцох боломж хязгаарлагдах, дотоод удирдлага зохион байгуулалтын тогтолцоо сулрах, Байгууллагын нэр хүнд, ажилтнуудын ажлын уур амьсгал, хөрөнгө оруулагч болон олон нийтийн итгэлд сөргөөр нөлөөлөх зэрэг эрсдэлийг үүсгэж болзошгүй байна.
2. Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн цалин хөдөлмөрийн хөлсийг тодорхойлох тусгайлсан дүрэм, журам, эрх зүйн зохицуулалт байхгүйгээс тайлант хугацаанд хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллаж байсан Гүйцэтгэх захирлын түр орлон гүйцэтгэгчийн сарын үндсэн цалин хөлсийг 20.0 сая төгрөгөөр тогтоосон, өмнөх онд түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байсан түр орлогын гэрээний биелэлтийг үнэлэх эрх зүйн зохицуулалтгүйгээс төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, үнэлэх журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, 31.8 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл 65.1. Өмчлөгч буюу түүнээс эрх олгогдсон этгээд нь өмчлөх эрхийнхээ тодорхой хэсгийг ажилтнаар дамжуулан хэрэгжүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлагын түвшний ажил үүрэг гүйцэтгүүлэх зорилгоор тухайн ажилтантай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулж болно, 65.2. Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд энэ хуулийн 49.1-д заасан нөхцөлөөс гадна дараах нөхцөлийг тусгаж болно, 65.2.1. Ажлын эцсийн үр дүн, хүлээх үүрэг хариуцлага, гэрээг дүгнэх журам, 65.2.2. Ажилтанд олгох урамшуулал, хангамж, хөнгөлөлт болон ашгаас олгох хувь хэмжээ, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйл 83.7. Энэ хуулийн 83.6-д заасан гэрээнд төлөөлөн удирдах зөвлөлийг төлөөлж, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга/ гарын үсэг зурах бөгөөд гэрээнд гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна, Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам 1.1 Энэхүү журмын зорилго нь төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал, төрийн өмчит компанийн гүйцэтгэх захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах дүгнэх, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, дүгнэх, урамшуулал олгох болон бусад холбогдох харилцааг зохицуулахад оршино, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15 дугаар

зүйл Хэмнэлтийн бусад арга хэмжээ 15.2.6.байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн:

1. Дотоод хяналтыг сулруулж компанийн санхүүгийн сахилга бат, ил тод байдал, мэдээллийн аюулгүй байдал алдагдах, байгууллагын нөөцийг үр ашиггүй зарцуулах, эрсдэлийг бий болгосон зөрчлийг таслан зогсоож, ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудит нь Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн ажлын тайланг хянан баталгаажуулж ТУЗ-д танилцуулж байх, албан шаардлага хүргүүлэв.

5.1.4 Компанийн засаглах удирдлагатай холбоотой

Илрүүлэлт: 2006 онд Монголын хөрөнгийн бирж ХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалыг хашиж байсан ажилтан нь Анард ХХК-тай Улаанбаатар хотын Бэлхийн зусланд ажилчдад зориулсан 16 айлын байр бариулах барилга угсралтын гэрээ байгуулж, 2006-2007 онд гэрээний дагуу 171.5 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг шилжүүлсэн. Гэвч гэрээний үүрэг биелэгдээгүй компани нь 136.2 сая төгрөгийг найдваргүй авлагын хасагдуулгаар хүлээн зөвшөөр байна. **Тухайлбал:**

1. 2006 онд ажиллаж байсан Гүйцэтгэх захирал аман хэлбэрээр Анард ХХК-ийн гүйцэтгэх захиралд Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд байрлах өөрийн төрсөн хүүгийн компани болох Бүрэн эрдэнэ монс ХХК-ийн барилгыг барь гэж үүрэг даалгавар өгсөнтэй холбогдуулан гэрээний үүрэг биелүүлээгүй болох нь Иргэний хэргийн анхан шатны шүүхээр тогтоогдсон,
2. Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх нь Анард ХХК-ийн гүйцэтгэсэн ажлыг Хөрөнгийн үнэлгээний төв ХХК-иар Бэлхийн зусланд 61.1 сая нэг зуун мянга/ төгрөгийн ажил, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд 43.2 төгрөгийн ажил гүйцэтгэсэн болохийг тогтоож, зөрүү 67.1 сая төгрөгийг Монголын хөрөнгийг бирж ХК-нд төлөхөөр шийдвэрлэсэн байна. **Гэвч:** Анард ХХК нь шүүхээр шийдвэрлэсэн мөнгөн дүнг Монголын хөрөнгийн Бирж ХК-нд гаргаж өгөөгүй байгаа ба Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ажиллагаа явуулахад Анард ХХК нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй, өмчлөлд эд хөрөнгө бүртгэлгүй улмаар төлбөрийг барагдуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн,
3. УБ Бэлхийн зусланд гүйцэтгэсэн 61.1 сая төгрөгийн барилгын ажил нь хувь хүний эзэмшлийн газар дээр дутуу баригдсан тул тухайн дутуу баригдсан барилгыг гүйцээн барих боломжгүй, компанийн балансанд бүртгэх боломжгүй, хөрөнгийг компанийн эзэмшилд шилжүүлэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн тул өнөөг хүртэл тухайн хөрөнгөнд ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйл 84.4.Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй, 84.4.1.хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх; 84.4.2.үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх; 84.4.3.компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах; 83 дугаар зүйл.Гүйцэтгэх удирдлага 83.8.Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна гэж заасантай тус тус нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн:

1. Монголын хөрөнгийн бирж ХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалыг хашиж байсан ажилтан нь Анард ХХК-тай Улаанбаатар хотын Бэлхийн зусланд ажилчдад зориулсан 16 айлын байр бариулах барилга угсралтын гэрээ байгуулж, 2006-2007 онд гэрээний дагуу

хийгдэх байсан ажил хийгдээгүй гэрээний үүрэг хангагдаагүй байгаа зөрчлийг таслан зогсоож, тус зөрчилтэй холбоотой эзэн холбогдогчийг тогтоож хариу арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.1.5 Дэмжих баримтын бүрдэл дутуу

Илрүүлэлт:

Дэмжих баримт дутуу буюу гэрээ байгуулаагүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, ямар ажил үйлчилгээ авсан болон ямар зориулалтаар зарцуулсан нь тодорхойгүй нийт 10 удаагийн 11.8 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн байна. Энэ нь байгууллагын дотоод хяналтын орчныг сулруулж, санхүүгийн тайлангийн үнэн зөв, бодит байдлыг алдагдуулах, зардлыг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн тайлагнах, цаашлаад ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг бий болгож байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1. “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” 14 дүгээр зүйл 14.3.1. “анхан шатны баримт бүрдүүлэх; 20 дугаар зүйл. 20.1.1.нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах”; 20.1.4. “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”; 20.1.2. “нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон хууль тогтоомжид харшилсан шийдвэрийг биелүүлэхээс татгалза”; гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн:

1. Дэмжих баримт дутуу буюу гэрээ байгуулаагүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, ямар ажил үйлчилгээ авсан болон ямар зориулалтаар зарцуулсан нь тодорхойгүй ажил гүйлгээ бүртгэдэг зөрчлийг таслан зогсоож, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу иж бүрэн нотлох баримтад үндэслэн бүртгэл тайлагналыг хөтлөж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2. Зөвлөмж

5.2.1 НББОУС 19 "Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж"

Илрүүлэлт:

Компанийн хөдөлмөрийн дотоод журам болон Хамтын гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлагын дагуу ажилтнуудад олгох тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой ирээдүйд үүсэх үүргийг НББОУС-19 “Ажилтны тэтгэмж” стандартад заасан шаардлагын дагуу тооцоолж, нөөц өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

Энэ нь НББОУС 19 "Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж"-ийн 51-т "Ажилтнууд тайлант үеийн туршид аж ахуйн нэгжид үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд тухайн ААН нь тогтоосон шимтгэлийн хөтөлбөрт уг үйлчилгээний хариу болгон төлөх шимтгэлийн өглөгийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө. Аль хэдийн төлсөн аливаа шимтгэлийг хассаны дараа, өр төлбөр (хуримтлагдсан зардал) байдлаар хэрэв аль хэдийн төлсөн шимтгэл нь тухайн тайлагнах үеийн эцсээс өмнөх үйлчилгээний хувьд төлөх ёстой шимтгэлийн дүнгээс илүү байвал уг урьдчилсан төлбөр нь тухайлбал ирээдүйн төлбөрүүдийн бууралт эсвэл мөнгөн буцаан олголт болох тэр хэмжээгээр аж ахуйн нэгж нь илүү төлөлтийг хөрөнгө (урьдчилж төлсөн зардал) гэж хүлээн зөвшөөрнө." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн:

Ажилчдын тэтгэвэр, тэтгэмжийн нөөцийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, хэмжилтийн дүнг тодорхойлох үндэслэлтэй суурьтай болох.

5.2.2 НББОУС 16 Үндсэн хөрөнгө "Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой"

Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд бүртгэлтэй, үлдэгдэл өртөггүй болсон, үндсэн үйл ажиллагаанд одоог болтол ашиглагдаж байгаа 73 нэр төрлийн Оффисын тоног төхөөрөмж, 74 нэр төрлийн Тавилга эд хогшил, нийт 147 нэр төрлийн хөрөнгүүдээс 32 нэр төрлийн үндсэн хөрөнгүүдийг сонгон авч 2025 оны 4 дүгээр сарын 2, 5 дугаар сарын 29-ний өдрийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт болон 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлд үндэслэн нийт 119,732.4 мянган төгрөгөөр дахин үнэлсэн байна. **Гэвч:**

- Дахин үнэлгээг хийхдээ тухайн хөрөнгийн бодит үнэ цэн болон ашиглалтын үлдсэн хугацааг мэргэжлийн үнэлгээ, техникийн дүгнэлтэд тулгуурлан бодитойгоор тодорхойлоогүй;
- Анхны өртгийн 50 хувиар үнэлж, 1-3 жилийн хугацаанд элэгдүүлэхээр тогтоохдоо Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС) 16 "Үндсэн хөрөнгө"-ийн шаардлага үзүүлэлт болох хөрөнгийг дахин үнэлэхдээ бүлгээр нь үнэлэх, дансны үнэ болон хөрөнгийн бодит үнэ цэн хооронд материаллаг зөрүү үүссэн эсэх зэрэг шалгуур үзүүлэлтийг харгалзан үзээгүй байгаа нь хөрөнгийн бодит үнэ цэнийг буруу илэрхийлэх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал алдагдах, тайлант хугацааны үр дүн буруу илэрхийлэгдэх, зэрэг эрсдэлийг бий болгосон;
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хөрөнгийн дахин үнэлгээг хийх арга аргачлалыг нарийвчлан тусгаж өгөөгүй;
- Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасны дагуу гадаад, дотоод хөрөнгийн биржид бүртгүүлсэн бүх төрлийн хувьцаат компаниуд хөрөнгийн дахин үнэлгээ хийхдээ үнэлгээний хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ гэж заасан боловч хөрөнгийг үнэлгээний хуулийн этгээдээр үнэлүүлээгүй байна.

Энэ нь НББОУС 16 Үндсэн хөрөнгө Параграф 31 "Дахин үнэлгээ хийхдээ тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой байх ёстой. Бодит үнэ цэнийг зах зээлийн нотолгоо, мэргэжлийн үнэлгээний дүгнэлтэд тулгуурлан тодорхойлно. Параграф 36 "Хэрэв үндсэн хөрөнгийн зүйлийг дахин үнэлэх бол тухайн хөрөнгийн харьяалагдаж буй үндсэн хөрөнгийн нийт ангийг дахин үнэлнэ. Параграф 38 "Хөрөнгүүдээс сонголт хийж дахин үнэлэх, түүнчлэн өөр өөр хугацааны өртөг ба дахин үнэлсэн үнэ цэнийг хольж, санхүүгийн тайланд тусгахаас сэргийлэхийн тулд үндсэн хөрөнгийн нэг анги доторх зүйлсийг нэгэн зэрэг дахин үнэлнэ. Хэдий тийм боловч тухайн ангийн хөрөнгүүдийн дахин үнэлгээг богино хугацааны дотор хийж дуусгах ба уг үнэлгээ нь одоогийн цаг үетэй нийцсэн шинэлэг байлгах үүднээс хөрөнгийн ангийг хэсэгчилсэн сууриар үнэлж болно, Параграф 50 "Элэгдлийн хугацаа нь хөрөнгийн ашиглалтын үлдсэн хугацаанд үндэслэн тогтоогдох бөгөөд тухайн хугацааг тогтмол хянаж, шаардлагатай бол шинэчилнэ гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн:

1. Дахин үнэлгээг хийхдээ тухайн хөрөнгийн бодит үнэ цэн болон ашиглалтын үлдсэн хугацааг мэргэжлийн үнэлгээ, техникийн дүгнэлтэд тулгуурлан бодитойгоор тодорхойлж байх;
2. Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу хөрөнгийг үнэлэхдээ нэг анги доторх зүйлсийг нэгэн зэрэг үнэлэх, мөн Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн дагуу хөрөнгийн үнэлгээг үнэлгээний хуулийн этгээдээр гүйцэтгүүлж байх.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(Мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<p>Компанийн засаглал, хүний нөөцийн удирдлага болон дотоод хяналтын хэрэгжилтэд илэрсэн зөрчил, дутагдал</p> <p>Компанийн өмнөх Гүйцэтгэх нь өөрийн эрх мэдлийг урвуулан ашиглаж хүний нөөцийн удирдлага болон дотоод хяналтыг сулруулж компанийн санхүүгийн сахилга бат, ил тод байдал, мэдээллийн аюулгүй байдал алдагдах, байгууллагын нөөцийг үр ашиггүй зарцуулах дараах эрсдэлийг бий болгосон байна. Тухайлбал:</p> <p>Өмнөх гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь компанитай байгуулсан хөдөлмөрийн гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд Нийслэлийн “Орон сууцны корпорац” ХК, Нийслэлийн өмчит “Улаанбаатар ХОМК” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр давхар ажилласан нь хөдөлмөрийн гэрээний үүрэг, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчим болон компанийн засаглалын шаардлагатай нийцээгүй</p> <p>Ажлын байрны чиг үүргийн шинжилгээ, хэрэгцээ шаардлагыг тодорхойлоогүй, сонгон шалгаруулалт зохион байгуулах ажлын хэсэг байгуулаагүй, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас ирүүлсэн орон тоог нэмэгдүүлэхгүй байх чиглэлийг дагаж мөрдөлгүй нийт 5 ажилтантай туршилтаар ажиллах гэрээ байгуулан ажиллуулсан байна.</p>	1	41,069.4	-	-	1	41,069.4	-	-	-	-

Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

<p>Гэвч туршилтын хугацаанд гүйцэтгэлийн үнэлгээ хийгдээгүй, зарим ажилтнууд зайнаас ажилласан, цагийн бүртгэл хөтлөгдөөгүй, гүйцэтгэсэн ажлын тайлан, үр дүн тодорхойгүй, ажлын гүйцэтгэлийн баримт хангалтгүй байхад нийт 41.0 сая төгрөгийн төсөвлөгдөөгүй цалингийн зардал гаргасан</p> <p>Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Захирлын зөвлөлийн зөвшөөрөлгүй Эрчист Монгол ХХК-ийн ажилчдыг 2025 оны 05 сарын 09-нөөс 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийг дуустал Б1 давхарт, 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрөөс 2025 оны 08 дугаар сарыг дуустал 2 давхрын хурлын өрөөнд суулган ажиллуулах чиглэл өгч тус компанийн ажилчдыг Монголын хөрөнгийн бирж ХК-ийн үндсэн үйл ажиллагаанд хамааралтай бус, зорилго нь тодорхойгүйгээр урт хугацаанд суулгаж ажиллуулж, өрөө тасалгаа, тавилга, тоног төхөөрөмж, интернэт сүлжээг ашиглуулсан бөгөөд мэдээллийн нууцлалын гэрээ байгуулаагүй байна</p>										
<p>Компанийн дотоод хяналтын үйл ажиллагааг үнэлэхэд дотоод хяналтын төлөвлөлт, тайлагнал, удирдлагын хяналт болон дотоод зохицуулалтын шинэчлэл хангалтгүй байна. Тухайлбал:</p> <p>2025 оны дотоод хяналтын төлөвлөгөөнд тусгасан хяналт шалгалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, дотоод хяналтын тайланг Биржийн гүйцэтгэх удирдлага болон захирлуудын зөвлөлд тогтмол хүргүүлээгүй, мөн хийсэн хяналт шалгалтын дүгнэлт, зөвлөмжид удирдлагын түвшинд үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангах арга, дотоод хяналтаар илэрсэн алдаа, дутагдлыг засаж залруулах зөвлөмж, заавар, арга хэмжээ авдаггүй, Түүнчлэн компанийн үйл ажиллагаанд мөрдөж буй зарим дотоод журам, бодлогын баримт бичгүүдийг холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан шинэчлэн батлаагүй байгаа нь байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн нийцэл алдагдах, дотоод хяналтын тогтолцоо сулрах эрсдэлийг бий болгож байна.</p>	1	-	-	-	1	-	-	-	-	

<p>Компанийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг ТУЗ нь Монгол Улсын Сангийн сайдаас ирүүлсэн албан бичиг болон Компанийн тухай хууль, компанийн дүрмийг үндэслэн тогтоол гарган томилж, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллуулж байна. Үүнээс үүдэн хууль эрх зүй, компанийн засаглалын зохицуулалттай холбоотой дараах гол зөрчил, эрсдэлүүд үүсэхээр байна Тухайлбал:</p> <p>Компанид тогтвортой хугацаанд ажиллах Гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулж томилоогүйн улмаас тайлант хугацаанд дөрвөн удаа Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч солигдсон нь компанийн засаглалын тогтвортой байдал, стратегийн төлөвлөлтөд сөргөөр нөлөөлөх, Удирдлагын байнгын өөрчлөлт нь дунд болон урт хугацааны бодлого, төлөвлөгөөний хэрэгжилт тасалдах, гүйцэтгэлийн шалгуур тогтоох болон хариуцлага тооцох боломж хязгаарлагдах, дотоод удирдлага зохион байгуулалтын тогтолцоо сулрах, Байгууллагын нэр хүнд, ажилтнуудын ажлын уур амьсгал, хөрөнгө оруулагч болон олон нийтийн итгэлд сөргөөр нөлөөлөх зэрэг эрсдэлийг үүсгэж болзошгүй байна.</p> <p>Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн цалин хөдөлмөрийн хөлсийг тодорхойлох тусгайлсан дүрэм, журам, эрх зүйн зохицуулалт байхгүйгээс тайлант хугацаанд хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллаж Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч сарын үндсэн цалин хөлсийг 20.0 сая төгрөгөөр тогтоосон, өмнөх онд түр орлон гүйцэтгэгч байсан орлон гүйцэтгэгчийн гэрээний биелэлтийг үнэлэх эрх зүйн зохицуулалтгүйгээс төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, үнэлэх журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, 31.8 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.</p>	1	51,833.2	-	-	1	51,833.2	-	-	-	-
<p>2006 онд Монголын хөрөнгийн бирж ХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалыг хашиж байсан ажилтан нь Анард ХХК-тай Улаанбаатар хотын Бэлхийн зусланд ажилчдад</p>	1	136,230.0	-	-	1	136,230.0	-	-	1	136,230.0

<p>зориулсан 16 айлын байр бариулах барилга угсралтын гэрээ байгуулж, 2006-2007 онд гэрээний дагуу 171.5 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг шилжүүлсэн. Гэвч гэрээний үүрэг биелэгдээгүй компани нь 136.2 сая төгрөгийг найдваргүй авлагын хасагдуулгаар хүлээн зөвшөөр байна. Тухайлбал:</p> <p>1. 2006 онд ажиллаж байсан Гүйцэтгэх захирал аман хэлбэрээр Анард ХХК-ийн гүйцэтгэх захиралд Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд байрлах өөрийн төрсөн хүүгийн компани болох Бүрэн эрдэнэ монс ХХК-ийн барилгыг барь гэж үүрэг даалгавар өгсөнтэй холбогдуулан гэрээний үүрэг биелүүлээгүй болох нь Иргэний хэргийн анхан шатны шүүхээр тогтоогдсон,</p> <p>2. Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх нь Анард ХХК-ийн гүйцэтгэсэн ажлыг Хөрөнгийн үнэлгээний төв ХХК-иар Бэлхийн зусланд 61.1 сая нэг зуун мянга/ төгрөгийн ажил, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд 43.2 төгрөгийн ажил гүйцэтгэсэн болохийг тогтоож, зөрүү 67.1 сая төгрөгийг Монголын хөрөнгийг бирж ХК-нд төлөхөөр шийдвэрлэсэн байна. Гэвч: Анард ХХК нь шүүхээр шийдвэрлэсэн мөнгөн дүнг Монголын хөрөнгийн Бирж ХК-нд гаргаж өгөөгүй байгаа ба Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ажиллагаа явуулахад Анард ХХК нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй, өмчлөлд эд хөрөнгө бүртгэлгүй улмаар төлбөрийг барагдуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн,</p> <p>3. УБ Бэлхийн зусланд гүйцэтгэсэн 61.1 сая төгрөгийн барилгын ажил нь хувь хүний эзэмшлийн газар дээр дутуу баригдсан тул тухайн дутуу баригдсан барилгыг гүйцээн барих боломжгүй, компанийн балансанд бүртгэх боломжгүй, хөрөнгийг компанийн эзэмшилд шилжүүлэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн тул өнөөг хүртэл тухайн хөрөнгөнд ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна.</p>									
---	--	--	--	--	--	--	--	--	--

Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

<p>Дэмжих баримт дутуу буюу гэрээ байгуулаагүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, ямар ажил үйлчилгээ авсан болон ямар зориулалтаар зарцуулсан нь тодорхойгүй нийт 10 удаагийн 11.8 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн байна. Энэ нь байгууллагын дотоод хяналтын орчныг сулруулж, санхүүгийн тайлангийн үнэн зөв, бодит байдлыг алдагдуулах, зардлыг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн тайлагнах, цаашлаад ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг бий болгож байна.</p>	1	11,847.6	-	-	1	11,847.6	-	-	-	-
<p>Компанийн хөдөлмөрийн дотоод журам болон Хамтын гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлагын дагуу ажилтнуудад олгох тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой ирээдүйд үүсэх үүргийг НББОУС-19 “Ажилтны тэтгэмж” стандартад заасан шаардлагын дагуу тооцоолж, нөөц өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.</p>	1	-	-	-	-	-	1	-	-	-
<p>Санхүүгийн тайланд бүртгэлтэй, үлдэгдэл өртөггүй болсон, үндсэн үйл ажиллагаанд одоог болтол ашиглагдаж байгаа 73 нэр төрлийн Оффисын тоног төхөөрөмж, 74 нэр төрлийн Тавилга эд хогшил, нийт 147 нэр төрлийн хөрөнгүүдээс 32 нэр төрлийн үндсэн хөрөнгүүдийг сонгон авч 2025 оны 4 дүгээр сарын 2, 5 дугаар сарын 29-ний өдрийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт болон 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлд үндэслэн нийт 119,732.4 мянган төгрөгөөр дахин үнэлсэн байна. Гэвч:</p> <p>Дахин үнэлгээг хийхдээ тухайн хөрөнгийн бодит үнэ цэн болон ашиглалтын үлдсэн хугацааг мэргэжлийн үнэлгээ, техникийн дүгнэлтэд тулгуурлан бодитойгоор тодорхойлоогүй;</p> <p>Анхны өртгийн 50 хувиар үнэлж, 1-3 жилийн хугацаанд элэгдүүлэхээр тогтоохдоо Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС) 16 “Үндсэн хөрөнгө”-ийн шаардлага үзүүлэлт болох хөрөнгийг дахин үнэлэхдээ бүлгээр нь үнэлэх, дансны үнэ болон хөрөнгийн бодит үнэ цэн хооронд материаллаг зөрүү үүссэн эсэх зэрэг шалгуур</p>	1	119,732.4	-	-	-	-	1	119,732.4	-	-

Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

<p>үзүүлэлтийг харгалзан үзээгүй байгаа нь хөрөнгийн бодит үнэ цэнийг буруу илэрхийлэх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал алдагдах, тайлант хугацааны үр дүн буруу илэрхийлэгдэх, зэрэг эрсдэлийг бий болгосон;</p> <p>Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хөрөнгийн дахин үнэлгээг хийх арга аргачлалыг нарийвчлан тусгаж өгөөгүй;</p> <p>Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасны дагуу гадаад, дотоод хөрөнгийн биржид бүртгүүлсэн бүх төрлийн хувьцаат компаниуд хөрөнгийн дахин үнэлгээ хийхдээ үнэлгээний хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ гэж заасан боловч хөрөнгийг үнэлгээний хуулийн этгээдээр үнэлүүлээгүй байна.</p>									
Дүн	7	360,712.6	-	-	5 240,980.2	2	119,732.4	1	136,230.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 699/АД150061

Улаанбаатар хот

САГ-2026/53/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг ТУЗ нь Монгол Улсын Сангийн сайдаас ирүүлсэн албан бичиг болон Компанийн тухай хууль, компанийн дүрмийг үндэслэн тогтоол гарган томилж, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллуулж байна. Үүнээс үүдэн хууль эрх зүй, компанийн засаглалын зохицуулалттай холбоотой дараах гол зөрчил, эрсдэлүүд үүсэхээр байна. Тухайлбал,

1. Компанид тогтвортой хугацаанд ажиллах Гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулж томилоогүйн улмаас тайлант хугацаанд дөрвөн удаа Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч солигдсон нь компанийн засаглалын тогтвортой байдал, стратегийн төлөвлөлтөд сөргөөр нөлөөлөх, удирдлагын байнгын өөрчлөлт нь дунд болон урт хугацааны бодлого, төлөвлөгөөний хэрэгжилт тасалдах, гүйцэтгэлийн шалгуур тогтоох болон хариуцлага тооцох боломж хязгаарлагдах, дотоод удирдлага зохион байгуулалтын тогтолцоо сулрах, байгууллагын нэр хүнд, ажилтнуудын ажлын уур амьсгал, хөрөнгө оруулагч болон олон нийтийн итгэлд сөргөөр нөлөөлөх зэрэг эрсдэлийг үүсгэж болзошгүй байна.
2. Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн цалин хөдөлмөрийн хөлсийг тодорхойлох тусгайлсан дүрэм, журам, эрх зүйн зохицуулалт байхгүйгээс тайлант хугацаанд хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллаж байсан түр орлон гүйцэтгэгчийн сарын үндсэн цалин хөлсийг 20,000,000 ₮ /хорин сая/ төгрөгөөр тогтоосон, Өмнөх онд түр орлон гүйцэтгэгч байсан түр орлонгийн хөлсөөр ажиллах гэрээний биелэлтийг үнэлэх эрх зүйн зохицуулалтгүйгээс төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, үнэлэх журамд заасан шалгуур үзүүлэлтийг үндэслэн болгон үнэлж, 31,833,209.00 /гучин нэгэн сая найман зуун гучин гурван мянга хоёр зуун есөн/ төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл 65.1-т "Өмчлөгч буюу түүнээс эрх олгогдсон этгээд нь өмчлөх эрхийнхээ тодорхой хэсгийг ажилтнаар дамжуулан хэрэгжүүлэх, аж ахуйн нээж, байгууллагын гүйцэтгэх удирдлагын түвшний ажил үүрэг гүйцэтгүүлэх зорилгоор тухайн ажилтантай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулж болно", 65.2-т "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд энэ хуулийн 49.1-д заасан нөхцөлөөс гадна дараах нөхцөлийг тусгаж болно, 65.2.1-т Ажлын эцсийн үр дүн, хүлээх үүрэг хариуцлага, гэрээг дүгнэх журам, 65.2.2-т Ажилтанд олгох урамшуулал, хангамж, хөнгөлөлт болон ашгаас олгох хувь хэмжээ, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйл 83.7-д Энэ хуулийн 83.6-д заасан гэрээнд төлөөлөн удирдах зөвлөлийг төлөөлж, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-34.Docx

1526180890

хурлын дарга/ гарын үсэг зурах бөгөөд гэрээнд гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна, Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам 1.1-т Энэхүү журмын зорилго нь төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал, төрийн өмчит компанийн гүйцэтгэх захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах дүгнэх, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, дүгнэх, урамшуулал олгох болон бусад холбогдох харилцааг зохицуулахад оршино, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15 дугаар зүйл Хэмнэлтийн бусад арга хэмжээ 15.2.6-д байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, түүний үр дүн, гэрээний биелэлтийг үнэлэх үр дүнгийн урамшуулал олгох журмыг холбогдох хууль, дүрэмд нийцүүлэн боловсруулж, гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчтэй байгуулж байгаа гэрээг хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох дүрэм журамд нийцүүлэн, үр дүн гэрээний биелэлтийг хэрхэн үнэлэх тухай тусгаж өгөх,
2. Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журмыг үндэслэн гэрээний биелэлтийг үнэлж үр дүнгийн урамшуулал олгож байгаа нь компанийн тухай хууль, компанийн дүрэм зэрэгтэй нийцэж байгаа эсэхийг үнэлэн дүгнэж холбогдох дээд шатны байгууллагаас заавар чиглэл авах, цаашид алдааг давтан гаргахгүй байх, албан шаардлагын биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Үндэсний аудитын газарт ирүүлэх;
4. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомж, компанийн дотоод дүрэм журмыг хэрэгжүүлж ажиллахыг ТУЗ-ийн дарга Д.Тогтохбаярт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН
УДИРДАХ ПАРТНЕР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
О.ИДШИНРИНЖИН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 698/А0150061

Улаанбаатар хот

САГ - 2026/53/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн дотоод хяналтын үйл ажиллагааг үнэлэхэд дотоод хяналтын төлөвлөлт, тайлагнал, удирдлагын хяналт болон дотоод зохицуулалтын шинэчлэл хангалтгүй байна. Тухайлбал,

2025 оны дотоод хяналтын төлөвлөгөөнд тусгасан хяналт шалгалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, дотоод хяналтын тайланг Биржийн гүйцэтгэх удирдлага болон захирлуудын зөвлөлд тогтмол хүргүүлээгүй, мөн хийсэн хяналт шалгалтын дүгнэлт, зөвлөмжүүдэд удирдлагын түвшинд үнэлгээ хийж үнэлээгүй, дотоод хяналтаар илэрсэн алдаа, дутагдлыг засаж залруулах зөвлөмж, заавар, арга хэмжээ авдаггүй, түүнчлэн компанийн үйл ажиллагаанд мөрдөж буй зарим дотоод журам, бодлогын баримт бичгүүдийг холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан шинэчлэн батлаагүй байгаа нь байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн нийцэл алдагдах, дотоод хяналтын тогтолцоо сулрах эрсдэлийг бий болгож байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйл 17.1.3-т "аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн үндэсний болон холбогдох стандарт, журам баталж, мөрдүүлэх", 18 дугаар зүйл 18.2-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 19 дүгээр зүйл 19.1-д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 145 дугаар тогтоолоор батлагдсан засаглалын кодекс Хавсралт-9 дотоод хяналтын зааврын үлгэрчилсэн загвар 1.1-д "энэхүү баримт бичгийг гүйцэтгэх удирдлага нь өөрийн дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ баримтлах зарчим, дотоод хяналтын үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлоход баримтална", 1.4-т "дотоод хяналт нь эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, арга зүйн зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэхэд чиглэнэ", 2.4.5-д "шаардлагатай бол илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар гүйцэтгэх удирдлагад санал тавьж, шийдвэрлүүлэх" 2.4.6-д "хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар ажилтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах" МХБ ХК-ийн Дотоод хяналт шалгалтын журам 11.1-т "дотоод хяналтын

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-260230

Z: Alban Shaardlaga\2026\0316 SAG-34.Docx


1526180888

ажилтан нь Биржийн гүйцэтгэх удирдлага болон захирлуудын зөвлөлд тайланг улирал тутам хүргүүлнэ". МХБ ХК-ийн дотоод аудитын журам 3.2.9-т "дотоод хяналтын үйл ажиллагааны үр ашигтай байдал" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дотоод хяналтын төлөвлөгөөг Гүйцэтгэх захирлаар баталгаажуулан төлөвлөгөөний дагуу дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, Гүйцэтгэх захирлын батлагдсан "Дотоод хяналт шалгалтын журам"-ын дагуу Биржийн Гүйцэтгэх удирдлага болон захирлуудын зөвлөлд дотоод хяналтын тайланг улирал бүр хүргүүлж байх,
2. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил болон зөвлөмжийн хэрэгжилт биелэлтийг үнэлж хариу арга хэмжээ авч байх, ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудит нь дотоод хяналтын үйл ажиллагааны үр ашигтай байдлыг үнэлж дүгнэж байх, албан шаардлагын биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Үндэсний аудитын газарт ирүүлэх;
3. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомж, компанийн дотоод дүрэм журмыг хэрэгжүүлж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудитын хорооны дарга Н.Улаанхүү, дотоод хяналтын ажилтан Б.Эрдэнэболор нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН
УДИРДАХ ПАРТНЕР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

О.ИДШИНРИНЖИН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 697/АД150061

Улаанбаатар хот

САГ - 2026/53/НА - СТА - ТВҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн өмнөх Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь өөрийн эрх мэдлийг урвуулан ашиглаж хүний нөөцийн удирдлага болон дотоод хяналтыг сулруулж компанийн санхүүгийн сахилга бат, ил тод байдал, мэдээллийн аюулгүй байдал алдагдах, байгууллагын нөөцийг үр ашиггүй зарцуулах дараах эрсдэлийг бий болгосон байна. Тухайлбал,

1. Өмнөх гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь компанитай байгуулсан хөдөлмөрийн гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд Нийслэлийн "Орон сууцны корпорац" ХК, Нийслэлийн өмчит "Улаанбаатар ХОМК" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр давхар ажилласан нь хөдөлмөрийн гэрээний үүрэг, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчим болон компанийн засаглалын шаардлагатай нийцээгүй;
2. Ажлын байрны чиг үүргийн шинжилгээ, хэрэгцээ шаардлагыг тодорхойлоогүй, сонгон шалгаруулалт зохион байгуулах ажлын хэсэг байгуулаагүй, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас ирүүлсэн орон тоог нэмэгдүүлэхгүй байх чиглэлийг дагаж мөрдөлгүй нийт 5 ажилтантай туршилтаар ажиллах гэрээ байгуулан ажиллуулсан байна. Гэвч туршилтын хугацаанд гүйцэтгэлийн үнэлгээ хийгдээгүй, зарим ажилтнууд зайнаас ажилласан цагийн бүртгэл хөтлөгдөөгүй, гүйцэтгэсэн ажлын тайлан, үр дүн тодорхойгүй, ажлын гүйцэтгэлийн баримт хангалтгүй байхад нийт 41,069,388.00 *Идэчин нэгэн сая жаран есөн мянга гурван зуун наян найм* төгрөгийн төсөвлөгдөөгүй цалингийн зардал гаргасан;
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Захирлын зөвлөлийн зөвшөөрөлгүй Эрчист Монгол ХХК-ийн ажилчдыг 2025 оны 05 сарын 09-нөөс 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийг дуустал Б1 давхарт, 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрөөс 2025 оны 08 дугаар сарыг дуустал 2 давхрын хурлын өрөөнд суулган ажиллуулах чиглэл өгч тус компанийн ажилчдыг Монголын хөрөнгийн бирж ХК-ийн үндсэн үйл ажиллагаанд хамааралтай бус, зорилго нь тодорхойгүйгээр урт хугацаанд суулгаж ажиллуулж, өрөө тасалгаа, тавилга, тоног төхөөрөмж, интернэт сүлжээг ашиглуулсан бөгөөд мэдээллийн нууцлалын гэрээ байгуулаагүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 17 дугаар зүйл 17.6-д "Ажил мэргэжлийн стандартаар хөдөлмөрийн нөхцөл, ажилтны ажлын дадлага, туршлага, мэдлэг, ур чадвар, чадамж, хандлага, мэргэшлийн түвшин, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тогтооно" Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47 дугаар зүйл 47.7-д "Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын эрх бүхий албан тушаалтан үнэт цаасны

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\2026\0316.SAG-34.Docx

1526180886

арилжаанд оролцогч зохицуулалттай хуулийн этгээдэд алив албан тушаал эрхлэхийг хориглоно" Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйл 18.1-д "албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно." 27.2-т "албан тушаалтан өөрийн үйл ажиллагааны шударга, төвийг сахисан байдалдаа ёс зүйн шалтгаанаар эргэлзээ төрвөл албан үүргээ гүйцэтгэхээс эсхүл давхар ажил, албан тушаал эрхлэхээс татгалзах үүрэгтэй." Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 8 дугаар зүйл 8.6.14-т "хуульд зааснаас бусад тохиолдолд өөр байгууллагад ажил, албан тушаал хавсран эрхлэхгүй байх" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3-т "үр ашигтай байх" 4.1.9-д "хариуцлагатай байх" 15 дугаар зүйл 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" Төрийн өмчийн хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журмын 1.5. "хуулийн этгээдийн ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалт явуулахдаа хууль дээдлэх, ил тод, хараат бус байх, ашиг сонирхлоос ангид байх, шударга, эрх тэгш хандах болон нээлттэй өрсөлдөөний зарчмыг удирдлага болгоно" 2.1.1-д "ажлын байранд чиг үүргийн шинжилгээ хийж, ажлын байр тус бүрийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох" 2.1.3-т "ажлын байрны тодорхойлолт (ажил үүргийн тодорхойлолт)-ыг батлах" 3.1-д "Ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалт (цаашид "сонгон шалгаруулалт" гэх) зохион байгуулах шийдвэрийг хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал гаргаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулна" СЗХ-ны Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагааны журмын 3.8.3-д "хуульд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэх удирдлага нь үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон банк, даатгал, бусад санхүүгийн компанийн гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаал хавсран эрхэлдэггүй байх" СЗХ-ны Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны журмын 2.1.2-т "гүйцэтгэх удирдлага, мэргэжилтэн нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу ажил, үйлчилгээний төрөлд нийцсэн эрх авсан байх бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол хавсран ажил эрхэлдэггүй байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.3-т "өмч хөрөнгийг бусдад зүй бусаар ашиглуулсан" 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дотоод хяналтыг сулруулж компанийн санхүүгийн сахилга бат, ил тод байдал, мэдээллийн аюулгүй байдал алдагдах, байгууллагын нөөцийг үр ашиггүй зарцуулах, эрсдэлийг бий болгосон зөрчлийг таслан зогсоож, ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудит нь Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн ажлын тайланг хянан баталгаажуулж ТУЗ-д танилцуулж байх, албан шаардлагын биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Үндэсний аудитын газарт ирүүлэх,

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбат-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН
УДИРДАХ ПАРТНЕР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Ө.ИДШИНРИНЖИН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 700/АД150061

Улаанбаатар хот

САГ-2026/53/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2006 онд Монголын хөрөнгийн бирж ХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалыг хашиж байсан ажилтан нь Анард ХХК-тай Улаанбаатар хотын Бэлхийн зусланд ажилчдад зориулсан 16 айлын байр бариулах барилга угсралтын гэрээ байгуулж, 2006-2007 онд гэрээний дагуу 171,500,000.00 /нэг зуун далан нэгэн сая таван зуун мянган/ төгрөгийн урьдчилгаа төлбөрийг шилжүүлсэн. Гэвч гэрээний үүрэг биелэгдээгүй компани нь 136,230,000.00 /нэг зуун гучин зургаан сая хоёр зуун гучин мянган/ төгрөгийг найдваргүй авлагын хасагдуулгаар хүлээн зөвшөөр байна. Тухайлбал:

1. 2006 онд ажиллаж байсан Гүйцэтгэх захирал аман хэлбэрээр Анард ХХК-ийн гүйцэтгэх захиралд Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд байрлах өөрийн төрсөн хүүгийн компани болох Бүрэн эрдэнэ монс ХХК-ийн барилгыг барь гэж үүрэг даалгавар өгсөнтэй холбогдуулан гэрээний үүрэг биелүүлээгүй болох нь Иргэний хэргийн анхан шатны шүүхээр тогтоогдсон,
2. Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх нь Анард ХХК-ийн гүйцэтгэсэн ажлыг Хөрөнгийн үнэлгээний төв ХХК-иар Бэлхийн зусланд 61,100,000.00 /жаран нэгэн сая нэг зуун мянган/ төгрөгийн ажил, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд 43,270,000.00 /дөчин гурван сая хоёр зуун далан мянган/ төгрөгийн ажил гүйцэтгэсэн болохийг тогтоож, зөрүү 67,130,000.00 /жаран долоон сая нэг зуун гучин мянган/ төгрөгийг Анард ХХК-иар төлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Гэвч: Анард ХХК нь шүүхээр шийдвэрлэсэн мөнгөн дүнг Монголын хөрөнгийн Бирж ХК-нд гаргаж өгөөгүй байгаа ба Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ажиллагаа явуулахад Анард ХХК нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй, өмчлөлд эд хөрөнгө бүртгэлгүй улмаар төлбөрийг барагдуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн;
3. Улаанбаатар Бэлхийн зусланд гүйцэтгэсэн 61,100,000.00 /жаран нэг сая нэг зуун мянган/ төгрөгийн барилгын ажил нь хувь хүний эзэмшлийн газар дээр дутуу баригдсан тул тухайн дутуу баригдсан барилгыг гүйцээн барих боломжгүй, компанийн балансанд бүртгэх боломжгүй, хөрөнгийг компанийн эзэмшилд шилжүүлэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн тул өнөөг хүртэл тухайн хөрөнгөнд ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйл 84.4-т "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй, 84.4.1-т хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх", 84.4.2-т "үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх, 84.4.3-т компанийн эрх ашигт нийцүүлэн

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z: Alban.Shaardlaga\2026\0316.SAG-34.Docx

1526180892

үндэслэлтэй шийдвэр гаргах; 83 дугаар зүйл. Гүйцэтгэх удирдлага 83.8-д "Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8 "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй"; 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Монголын хөрөнгийн бирж ХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалыг хашиж байсан ажилтан нь Анард ХХК-тай Улаанбаатар хотын Бэлхийн зусланд ажилчдад зориулсан 16 айлын байр бариулах барилга угсралтын гэрээ байгуулж, 2006-2007 онд гэрээний дагуу хийгдэх байсан ажил хийгдээгүй гэрээний үүрэг хангагдаагүй байгаа зөрчлийг таслан зогсоож, тус зөрчилтэй холбоотой эзэн холбогдогчийг тогтоож хариу арга хэмжээ авч ажиллах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ТУЗ-ийн дарга Д.Тогтохбаяр, Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН
УДИРДАХ ПАРТНЕР



Ц.НАРАНЧИМЭГ
ЧАНЦАЛДУЛАМ

О.ИДШИНРИНЖИН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 701/АД 150061

Улаанбаатар хот

САГ - 2026/53/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дэмжих баримт дутуу буюу гэрээ байгуулаагүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, ямар ажил үйлчилгээ авсан болон ямар зориулалтаар зарцуулсан нь тодорхойгүй нийт 10 удаагийн 11,847,619.00 /арван нэгэн сая найман зуун дөчин долоон мянга зургаан зуу аван есөн/ төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн байна. Энэ нь байгууллагын дотоод хяналтын орчныг сулруулж, санхүүгийн тайлангийн үнэн зөв, бодит байдлыг алдагдуулах, зардлыг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн тайлагнах, цаашлаад ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг бий болгож байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" 14 дүгээр зүйлийн 14.3-д. "анхан шатны баримт бүрдүүлэх; 20 дугаар зүйлийн 20.1.1-т "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах", 20.1.2-т "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон хууль тогтоомжид харшилсан шийдвэрийг биелүүлэхээс татгалзана" 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.8-д "байгуулсан гэрээ хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дэмжих баримт дутуу буюу гэрээ байгуулаагүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, ямар ажил үйлчилгээ авсан болон ямар зориулалтаар зарцуулсан нь тодорхойгүй ажил гүйлгээ бүртгэдэг зөрчлийг таслан зогсоож, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу иж бүрэн нотлох баримтад үндэслэн бүртгэл тайлагналыг хөтлөж байх, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Үндэсний аудитын газарт ирүүлэх;


Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-34 Docx

1526180894

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомж, компанийн дотоод дүрэм журмыг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбат, Захиргаа, санхүүгийн газрын захирал Х.Эрдэнэбүрэн, Ерөнхий нягтлан бодогч Д.Нарангэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН
УДИРДАХ ПАРТНЕР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
О.ИДШИНРИНЖИН